

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАРЫН ТУХАЙ ЦӨӨН ҮГ

Б. Балдоо

1991 онд Владивосток хотод ЗСБНХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын салбарын Далайг эзэмших эдийн засаг, олон улсын асуудлын хүрээлэн (одоо Ази Номхон далайн судалгааны хүрээлэн)-ээс эрхлэн А. Шкуропат, М. Терский, В. Вьюрков нарын бичсэн «Зүүн хойт Азийн орнуудын эдийн засгийн загвар» гэдэг товхимлыг хэвлэн нийтэлжээ. Энэ товхимолд Зүүн хойт Азийн үйлдвэржсэн, хөгжилтэй орнуудад (тухайлбал Япон, БНСУ, АНУ)-д хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй эдийн засгийн хөгжлийн загварын асуудал, энэ талаар ЗХУ, БНХАУ-д хийгдэж байсан алхамуудын тухай өгүүлжээ. Тэнд өгүүлэгдсэн материалаас түүвэрлэн энэхүү өгүүллийг бэлтгэв.

Өнөөдөр даян дэлхийн соёл иргэншлийн үйл явцыг шинэ соргогоор ажиг харахад хүргэж буй гүнзгий өөрчлөлтүүд ертөнц даяар явагдаж байна. Бүс нутгийн соёл иргэншлүүд бие бие өөд дөхөн ойртохын эдийн засгийн бодит үндэс нь бүх дэлхийн зах зээлийн аж ахуй бүрэлдэн тогтох нийтлэг интеграцийн үйл явц болж байгаа ажээ. Үүний эерэг үр дүнг ухааран ойлгож, прогнозчилох явдал олон улсын бодлогын нэг чухал зорилт болж байна.

Интеграцийн хурдавчилсан үйл явц ажиглагдаж, үлэмж чухаг соёлтой, хөдөлмөрлөх хүч, түүхий эдийн засар их нөөцтэй, өндөр хөгжсөн технологийн баазтай дэлхийн худалдааны шинэ төв эмхрэн бүрдэж буй Зүүн хойт Азийн (ЗХА) бүс нутгийн орнууд энэ талаар их анхаарал тавих болжээ.

Эдийн засгийн өсөлтийн динамикаар ЗХА-ийн Япон, БНСУ зэрэг орон дэлхийн эдийн засагт хошуучлах үүрэг гйцэтгэж байна. Дээрх интеграцийн үйл явцад ОХУ ба БНХАУ, ялангуяа тэдгээрийн Алс Дорнодын болон Зүүн хойт бүс нутаг, энэ районы бусад орон татагдан орж байна. Эдгээр орны хувьд дэлхийн эдийн засгийн орон зайтай хурдавчлан интеграцилагдах үзэл баримтлал, ялангуяа нийгэм эдийн засгийн янз бүрийн хэвлшүүд харилцан идэвхтэй үйлдэлд орох

¹ Б. Балдоо. ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн тэргүүлэх ажилтан

механизм зэргийг боловсруулах явдал хэдийнээ тулгам асуудал болжээ. Ийм интеграцийн үйл явцийн хөгжилд эдийн засгийн чөлөөт бүсүүд чухал түлхэц нөлөөтэй.

Дэлхийн практикаас үзвэл эдийн засаг, улс төрийн өргөн цар хүрээтэй, бүрэн гүйцэд харилцан үйлдлийн зайлшгүй нөхцөл нь интеграцид оролцож буй талууд буюу улсуудад эдийн засгийн ойролцоо систем (аж ахуйн загвар) байх явдал ажээ. Иймээс бүс нутгийн интеграцид шинэ тутам орж буй орнууд дотооддоо зах зээлийн механизмыг жинхэнэ ёсоор зүгшрүүлэх, бас зах зээлийн зүгширсэн механизмтай болсон АНУ, Япон, БНСУ зэрэг оронтой тэргүүлэх чигээр эрчимтэй хамтын ажиллагааг явуулах нь дэлхийн зах зээлд амжилттай оролцох үйл явцыг хурдасгахад сайн нөлөө үзүүлэх болно. Тэгэхдээ дурдсан орнуудтай арилцан үйлдэл хийснээс гарч болох үр ашгийг задлан шинжлэх нь улс орноо дэлхийн дээд үзүүлэлтүүдээр баримжаалах, эдийн засгийн илүү үр ашигтай загварт таацуулахад зайлшгүй хэрэг болох учиртай.

Зах зээлийн эдийн засгийн загваруудыг задлан шинжлэх нь бүс нутагт явагдаж байгаа интеграцид оролцож байгаа тодорхой орон бүр дэлхийн иргэншлийн үйл явцад хаана нь явж байгааг ойлгоход бас хэрэгтэй юм байна. Орос орон Өрнө, Дорнын соёлын харилцан үйлдэлд уникал байр эзэлж байгаа явдал, энэ үйл явцад дурдсан хоёр соёл харилцан сүлжлэлдсэн Алс Дорнодын бүс нутаг өвөрмөц роль гүйцэтгэх явдал нь дурдсан асуудлыг тулгам болгож байна. Өнөөдөр «Өрнөд-Орос-Дорнод» гэсэн гурван хэв шинжийн соёлын тухай ярьж болох бөгөөд эдгээрийн, ялангуяа эдийн засгийн бүрэлдүүн хэсгүүдийн нь харилцан үйлдэл нь ХХI зууны иргэншлийг тодорхойлно гэсэн дүгнэлтийг Оросын эрдэмтэд хийжээ.

Зах зээлийн эрүүл орчныг бий болгоход тодорхой нөхцөлүүд, дор хаяад дараах гурван нөхцөл хэрэгтэй. Үүнд олон улсын стандартад тохирохуйц иргэний нийгмийг бүрэлдүүлэх, өөрийн ч гэсэн, гадаадын ч гэсэн хөрөнгө оруулагчдын зүгээс хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөлийг бүрдүүлэх, аж ахуйн субъектууд олон улсын тавцан дээр өрсөлдөх чадварыг удаан хугацаанд хангах явдал юм.

Улс орны эдийн засгийн тодорхой загвар нь нэг хэмжигдэхүүнт үзэгдэл биш, харин эдийн засгийн ерөнхий механизмууд соёлын болон аж төрөх ёсны өвөрмөц уламжлалуудтай нэгдэн нийлсэн нэн чухаг сүлжилтийн бүтээгдэхүүн юм. Зах зээлийн загваруудын хэв маяг нь янз бүрийн үндсэн дээр тодорхойлогддог боловч, загвар бүр нь ерөнхий социологийн шинжүүд, үндэсний онцлогуудыг тусгаж байдаг. Зах зээлийн элементүүдийн харилцан үйлдэл нь нийгмийн капиталын дахин үйлдвэрлэлийн үйл явцыг нөхцөлдүүлэгч эрэлт ба нийлүүлэлтийн хэлбэлзлэлийг дамжин хэрэгжинэ. Энэ хөдөлгөөн нь хөдөлмөрийн нөөц ба үр бүтээлийг үйлдвэрлэх, хуваарилах, солилцох, хэрэглэх гэсэн шатуудыг дамжина. Тэгэхэд үйлдвэрлэлийн үйл явц дотор төв байрыг хэрэглээ эзэлнэ. Чухам л энэ шатан дээр бүтээгдэхүүн нь нийгмийн учир холбогдолтой болдог.

Дайны дараах жилүүдэд Зүүн хойт Азийн орнууд зах зээлийн бүтцийн хөгжлийн гурван шатыг туулан өнгөрчээ. Эдгээр бүтцүүд бие биенээс юугаар ялгаварлагдах вэ гэвэл хэрэглээний таваарыг аминд хэрэглэх явдал, үйлдвэрлэх янз бүрийн хэв маяг, хөрөнгө оруулалтын шинж байдал, «бизнес-төр» хоёрын харилцааны онцлогууд, эдийн засгийн нээлттэй байдлын түвшингээр ялгаварлагдана.

Зах зээлийн загварын ангилал

Хэрэглээний зонхилох хэв маяг	Үйлдвэрлэлийн хэв маяг	Зардлын хэв маяг	Удирдлагын харилцааны шинж төлөв	Эдийн засгийн нээлттэй байдлын төвшин
1. Тэргүүн ээлжийн (анхан шатны) хэрэгцээг хангах	Сериэр үйлдвэрлэх (хязгаарлагдмал)	Хөдөлмөр ихэд шингээсэн	Захиргаа-авторитар шинжтэй	Хаалттай
2. Амины хэрэгцээг өргөтгөсөн байдлаар хангах	Массаар үйлдвэрлэх (хязгаарлалтгүй)	Капитал ихэд шингээсэн	Ардчилсан нөхөрлөлийн (түншлэлийн) шинжтэй	Капиталын хувьд нээлттэй, таваарын хувьд хаалттай
3. Бодгальчилсан (хүн бүрийн хүсэмжилсэн) хэрэгцээ	Массаар бодгальчилан үйлдвэрлэх (захиалгаар)	Шинжлэх ухаан ихэд шингээсэн	Хүмүүнлэг тэгш эрхийн шинжтэй	Нээлттэй

Энэхүү ангилал бол үйл явцын мөн чанарыг ойлгоход туслах логик хийсвэрлэл учир загварууд нь бодит байдал дээр орон зай, цаг хугацааны хувьд бие биетэйгээ нягт сүлжилдсэн байдаг. Зах зээлийн эдийн засгийн хэв маяг нь үндсэндээ хэрэглээний шинж төлөв хийгээд чиглэлээр тодорхойлогдох ажээ. Хэрэглээний эрэлтийн динамик, нийгмийн хэрэгцээний чанарын өөрчлөлт нь үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээнд нөлөөлөхөөр барахгүй, үйлдвэрлэлийн бүтцийн хувиралт өөрчлөлт, түүний салбарууд болон хүрээнүүдэд эдийн засгийн нөөцийг оноон хуваарилах явдалд нөлөөлнө.

Аж үйлдвэр хөгжсөн орнууд дэлхийн II дайнаас хойших жилүүдэд хүмүүсийн үндсэн (тэргүүн ээлжийн) эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн зах зээлийн загвар-нэгдүгээр загвараас өргөн олны (массын) эрэлт хэрэгцээг хангах хоёрдугаар загварт, түүнээс «хүн бүрийн хүсэмжилсэн эрэлт хэрэгцээг» хангах гуравдугаар загварт шилжих замыг туулжээ. Улс орон бүр өөрийн хүрвэл зохих хэрэглээний тодорхой хэв маягаар (төвшинөөр) баримжаа хийх нь нийгмийн хөгжлийн зорилгодоо ойртох замд гаргах амжилтуудыг хамгаас сайн тодорхойлж өгнө.

Улс орны эдийн засгийн загвар бол шинжлэх ухааны ухагдахуун учраас бусад ухагдахуунтай харилцан хамааралд байдаг юм. Гносологийн төвшинд авч үзвэл эдийн засгийн загвар нь тодорхой эдийн засгийн орчны үндсэн онцлогуудыг тусгадаг. Тэгэхдээ онолын схем нь эдийн засгийн бодит системээс ялгаатай. Энэ бүгдээс үндэслэн, эдийн засагт явагдаж байдаг, хөгжлийн хурд болон пропорцыг тодорхойлдог нэн чухал, онцгой үйл явдлуудын нийлбэр цогцыг эдийн засгийн загвар гэж шинжлэх ухааны ном зохиолд ойлгодог байна.

Алив орны эдийн засгийн хөгжлийг хурдасгахад нөлөөлдөг гол хүчин зүйлсийг тодорхойлох асуудал нь олон улсын хөдөлмөрийн хуваарьт хэрхэн оролцож буй асуудалтай нягт холбоотой юм. Үүнтэй холбогдон улс орны хөгжлийн эдийн засгийн загвар болон түүний бойжилтын төвшиний тухай ухагдахуун нь «эдийн засгийн интеграцийн» тухай ухагдахуунтай харилцан авцалдаатай байдаг.

Анх 1950-иад оны үед неолиберал чиглэлийн эдийн засагчид (А. Мюллер-Армак, А. Предоль, Б. Репке болон бусад) «Интеграц» гэдэг ухагдахууныг бий болгож онолын хувьд үндэслэжээ. Тэд хэд хэдэн орны хүрээнд зах зээлийн хүчин чөлөөтэй үйлчилж байх зах зээлийн нэгдсэн орон зай байгуулах явдлыг интеграц гэж тодорхойлсон байна. «Интеграци» гэсэн нэр томъёог тайлбарласан хэд хэдэн

чиглэл гарчээ. Үүнд: чөлөөт худалдааны зарчмын үндсэн дээр интеграцид орж буй орнууд нэгдэн нийлэх явдал юм гэсэн зах зээлийн (буюу неолиберал) сургуулийн чиглэл; зах зээлийн үйл явцад төрөөс оролцох явдал зайлшгүй чухлыг үндэслэсэн дирижист чиглэл; интеграцийн үйл явц дахь зах зээлийн ба төрийн зохицуулалтын талуудын хоорондох харилцан буулт (компромисс)-ыг олох гэж оролдсон зах зээл-институционал чиглэл зэргийг дурдаж болох юм.

Интеграцид оролцох тодорхой зорилгот баримжаа нь хөгжлийг урагшлуулах хүчирхэг хүчин зүйл болдог боловч эдийн засгийн хөгжлийн янз бүрийн төвшинд оршиж буй (хэрэглээний төвшин ба стандарт, үндэсний заншил, материаллаг ба оюуны үнэт зүйлсийн систем зэргээр зарчмын ялгаатай) улсууд-түншүүд нэг интеграцид оролцох болсноос үүдсэн сүрхий хязгаарлалтай учирдаг байна. Ийм нөхцөлд хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал нь буурай хөгжилтэй орноос уян хатан бодлого явуулж, зайлшгүй цагт буулт хийж байх, улс ардын аж ахуйн цаг үеийн байдлаа байнга задлан шинжилж, нийгмийн харилцааг цаг үед нь зохицуулж байхыг шаардана. Эдийн засгийн хөгжлийн ойролцоо төвшинд байгаа улсуудын хооронд эдүгээгийн дээд хэлбэрийн интеграци жинхэнэ ёсоор явагдаж байгаа бөгөөд буурай хөгжилтэй орнууд дэлхийн лидер (хошуучлагч) орнуудтай интеграцид оролцох эдийн засгийн чиг шугам баримтлах нь өнөө үгүй гэхэд маргааш аж үйлдвэрийн бүтцийг өөрчлөх, аж ахуйг хөтлөх шинэ механизмыг нэвтрүүлэх хурдан замыг эрж хайхад нэн хэрэгтэй юм. Аж үйлдвэр хөгжсөн орнуудын жишээнээс үзвэл дэлхийн хамтын нийгэмлэгт орох зайлшгүй шалгуур баримжаа нь хэд хэдэн нөхцөлөөс, тодорхой хэлбэл дараах гурван нөхцөлөөс бүрдэнэ. Үүнд: эдийн засагт үр ашигтай өрсөлдөх механизмыг бий болгох; өрсөлдөх үндэсний эрдэм шинжилгээний баазыг хөгжүүлэх; өндөр технологийн суурь дээр эдийн засгийн бүтцийг өөрчлөх бололцоог бүрдүүлэх явдал болно. Өндөр технологид микроэлектроника, мэдээлэл зүй; генийн инженер зүй, биотехнологи; суурь машин, автомашин болон хөлөг онгоцны үйлдвэрлэлд хэрэглэх шинэ материал ба технологийг оруулан тооцдог аж.

Зах зээлийн загваруудыг хүмүүсийн хэрэгцээг хэр хангаж буй төвшинөөр ангилсан дээр дурдсан ангилалаас ургуулан харахад нэгдүгээр загвар нь хүмүүсийг хүнс хоол, хувцас хунараар юуны түрүүн хангахад чиглэгдсэн учир энэ нь материалын эрэлт хэрэгцээний энгийн нөхөн үйлдвэрлэлийг тусгаж байна. Тус тус орнуудын эдийн засгийн загваруудыг харьцуулан үзсэн үүднээс тэмдэглэхэд АНУ-д зах зээлийг хүн амын өдөр тутмын хэрэгцээний таваар болон үйлчилгээгээр хангах асуудал 20-иод оны эцсээр шийдвэрлэгджээ. Хэрэглээний нормоор тооцсон тоо хэмжээ, рацион дээр үндэслэсэн бөгөөд задлан хуваагаагүй эрэлт хэрэгцээний баазад түшиглэсэн зах зээлийн бүтэц Японд 50-иад оны эцсээр, БНСУ-д 60-аад онд бий болжээ. Эдгээр асуудлыг шийдвэрлэх явдал ЗХУ (хуучин нэрээр) болон БНХАУ-д өнөөдөр үргэлжилж байна.

Зах зээлийг тэргүүн ээлжийн хэрэгцээний таваар болон үйлчилгээгээр хангах нэг үзүүлэлт нь статистикийн дундач гэр бүлийн хоол хүнсэнд зарах зардлын хэмжээ байдаг ажээ. Хэрэв хүн амын дийлэнх хэсгийн гэр бүлийн төсвийн бүтэцэд хоол хүнс 50-иас дээш хувийг эзэлж байвал эдийн засгийн энэ хэв маяг нь энгийн нөхөн үйлдвэрлэлийн загварт хамаарах юм. 1980-аад онд статистикийн дундач гэр бүл төсвийнхээ хичнээн хувийг хоол, хүнсэнд зарцуулж байсныг авч үзвэл БНХАУ-д 80-аад хувь, ЗХУ-д 60-аад хувь, БНСУ-д 40 хувь, Японд 20 хувь, АНУ-д 15 хувь байжээ.

Олон нийтийн эрх ашгийг үл харгалзан дээд зэргийн ашиг олох явдлаар баримжаалсан, тэргүүн ээлжийн хэрэгцээг хангах технологийн бүтэц нь үр ашгийн дээд (туйлын) төвшиндээ хүрч, зах зээлийн эдийн засгийн хямралын цаашдын гүнзгийрэлт өөд хөтлөх болсныг ХХ зууны дунд үеийн хэт үйлдвэрлэлийн хямрал (юуны өмнө 30-аад оны Их хямрал) харуулсан юм. Ийм байдал зах зээлийн сөрөг үр дагаврыг «сааруулах» үр ашигтай механизм эрэн хайхад түлхэц болжээ. Тэгээд зах зээлийн харилцааг боловсронгуй болгох, хүн амын янз бүрийн бүлгийн эрэлт хэрэгцээг идэвхжүүлэх, ядуу хэсгийн хэрэглээний төвшинг хамгаалах нийгмийн хамгаалалтын баталгаатай системийг тогтооход чиглэгдсэн төрийн программгүйгээр үйлдвэрлэлийн үр ашгийг цаашид дээшлүүлж болохгүй гэдэг нь тодорхой болжээ. Үүнийг ухаарсны дунд төрийн хуваарилах үүргийг хүчтэй болгож, нийгмийн хөгжил болон хангамжид зарцуулах төрийн зардлыг өсгөх хандлага гарчээ. Энэхүү шинэ хандлага төрийн зохицуулалтын тухай Ж. М. Кейнсийн онолуудад бүх талаар бүрэн боловсрогджээ. 50—60-аад онд Зүүн хойт Азийн (АНУ, Япон, БНСУ) улсуудын засгийн газар энэхүү үзэл баримтлалыг ашиглан зах зээлийн конъюнктурын хэлбэлзлэлийг тогтоон барьж эдийн засгийн хөгжилдөө амжилт олсон байна.

Нэгдүгээр загварын хүрээнд хүн ам орлогоороо нийгмийн давхраануудад хуваагдах явдал дээд цэгтээ хүрч, нийгмийн хэрэгцээг өргөтгөн нөхөн үйлдвэрлэх явдал зөвхөн том ба дунд капиталын эзэд, өндөр цалинт мэргэжилтэн зэрэг явцуу хүрээнийхэнд л бололцоотой боллоо. Ангийн зөрчил хүчтэй болж, нийгмийн бүх мэргэжлийн бүлгүүдийн олон нийтийн тэмцэл өрнөсөн байна.

Хэрэглээний төвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн эдийн засгийн хөтөлбөрийг биелүүлсэн нь хүн амын хөдөлмөрийн чадвартай хэсгийн «олон нийтийн эрэлтийг» хангахад зориулсан зах зээлийн бүтцийг буюу эдийн засгийн хөгжлийн хоёрдугаар загварыг бүрдүүлэхэд хүргэсэн юм.

Хоёрдугаар загварын онцлог шинж бол нийгмийн тодорхой бүлгүүдийн хэрэгцээний эрэлтээр баримжаалсан, бас чанар, хийц, өртөг, хэрэгцээний шинж байдлаар янз янзын барааг үйлдвэрлэн гаргах явдлаар баримжаалсан, гэр бүлийн орлогын бүтцийг тооцоолсон тийм технологийн бүтцийг бий болгоход оршдог юм. Тэгэхдээ «технологийн систем» гэдэг ойлголтод үйлдвэрлэлийн үйл явцаас гадна нийгмийн гол үйлдвэрлэгч хүчин болсон хүнийг нөхөн үйлдвэрлэх явдлыг багтаан оруулдаг байна. Ийм хэв шинжийн эдийн засгийг байгуулахын тулд АНУ 100 гаруй жилийг зарцуулсан бол Япон 15 жил, БНСУ 20 жилийг зориулсан ажээ. Энэ шатны үндэс нь капитал их шингээсэн үйлдвэрлэх хүчний бүтцийг бүрдүүлэх, нийгмийн үйлдвэрлэлийг нэвтрүүлэх явдал ажээ. Тэгэхлээр энэ нь нөхөн үйлдвэрлэлийн эрчимтэй хэв маягт шилжих шилжилтийг хэрэгжүүлнэ гэсэн хэрэг юм.

Гурван зохиогчийн бичсэнээр 80-аад оны нэгдүгээр хагасаас ЗХУ массаар үйлдвэрлэх зах зээлийн загварт шилжих шилжилтийг эхэлжээ. Тэгэхдээ хөдөлмөрийн чадвартай хүн амын түрүү ээлжийн (үндсэн) хэрэгцээг хангах талаарх нэлээд асуудлыг шийдэлгүй энэ шилжилтийг эхэлсэн бөгөөд зах зээлийн нэгдүгээр, хоёрдугаар загварын хэрэгжих механизмууд нь өрсөлдөөний хэлбэр, хүн амыг нийгмийн талаар хамгаалах арга хэрэгсэл, төр капитал хоёр харилцах зарчим зэргээрээ бие биенээс сүрхий ялгагдахыг анхааран үзэх ёстой байжээ. 80-аад онд ЗХУ төлөвлөгөөт эдийн засгийн хүрээнд хүн амын

олон нийтийн хэрэгцээг хангах асуудлыг шийдвэрлэхээр бүтэлгүй оролдлого хийсний дараа улс төрийн тогтолцооны механизмыг өөрчлөх, төлөвлөлтөт зах зээлийн буюу шилжилтийн хэв шинжийн загварыг эрэлхийлэх замд оржээ. Иймэрхүү хэв шинжийн эдийн засагт шилжих шилжилтийг 70-аад оны эцсээр эхэлсэн БНХАУ зөвхөн XXI зууны дундуур эдийн засгийн суурь салбаруудаа капитал их шингээсэн технологид шилжүүлэх, массаар үйлдвэрлэх системийг нэвтрүүлэхээр төлөвлөсөн аж.

Олон нийтийн хэрэглээний нийгэмд шилжих явдлын үндэс суурь болсон гол нөхцөл нь үйлдвэрлэлийг хурдан өөрчлөн байгуулж бараа таваарыг үзэмж чанараар нь сольж байх бололцоо олгодог технологийн баазыг байгуулах явдал юм. Чухам энэ үед зар реклам, дизайн, баталгаатай үйлчилгээ, пүүсийн худалдааны тэмдэг гэх зэргийн өрсөлдөөний хэлбэрүүд их ач холбогдолтой болж ирсэн байна. Массаар үйлдвэрлэх тогтолцоо нь үйлдвэрлэлийн материалын зардлыг, тэр чанараараа таваарын үнийг нэлээд бууруулахад хүргэсэн бөгөөд зах зээл нь өндөр үр ашгийг хангахын тул шинжлэх ухааны салбар, маркетингийн системийг ихэд хөгжүүлжээ.

Олон нийтийн эрэлтийг хангах эдийн засгийн загвар нь хэрэглээний зах зээл дэх үнийг төрийн зүгээс шууд хянах явдлаас зайлсхийхэд хүргэжээ. Гэхдээ зах зээлийн эдийн засагт төрийн зохицуулалтын элемент ороогүй үнэ гэж ер нь байхгүй юм. Өмнөх шатанд өдөр тутмын эрэлт хэрэгцээт бараа таваарын хязгаар үнийг захиргааны аргаар төр олонтоо тогтоож байсан бол шинэ загварын шатанд шууд биш зохицуулалтын механизмд (цалин хөлсний доод хэмжээ, зээлийн капиталын хүү, гаалийн татвар, экспорт-импортод үзүүлэх тусламж, ашгийн татвар, хүн амын орлогын татвар, элэгдлийн норм гэх мэтэд) тэргүүлэх үүрэг өгдөг байна.

Үйлдвэрлэлийн бус дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулсан төрийн зардлын өсөлт, «бүгдийг ажилтай» болгох, ядуу давхрааны нийгмийн хэрэглээний төвшинг баталгаатай дээшлүүлэх гэсэн эрмэлзлэл зэрэг нь 60—70 онд шинэ хямрал («стагфляци») бий болгов. Үйлдвэрлэлийн суурь салбаруудын ашиг орлого ихэд доройтсон унах болжээ.

Энэ бүгд нь аж үйлдвэр хөгжсөн орнуудыг зах зээлийн харилцааг төрийн зүгээс зохицуулах явдлын шинэ хэлбэрийг эрэлхийлэхэд хүргэв. Ийнхүү АНУ, Япон улсад дунд хугацааны ба удаан хугацааны эдийн засгийн хөтөлбөрүүдийг зохиох зорилгоор судалгааны ажлыг өрнүүлсэн юм. Эдгээр судалгаанд хувийн эздийн идэвхийг урамшуулах механизмуудад гол анхаарлаа хандуулжээ. Пүүсүүд удирдлагын шинэ технологийг нэвтрүүлж эхэлжээ.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны шинж төрх өөрчлөгдсөн явдал марко эдийн засгийн тэнцлийг загварчилах ба прогнозчилох, маркетинг, удирдлагын сэтгэц зүй, худалдан авагчдын зан төрхийн талаар баримтлах стратеги, тактикийг боловсруулах ажил эрхэлсэн эрдэм шинжилгээний төвүүд олноор байгуулагдан ажиллажээ.

Бий болсон нийгэм-эдийн засгийн байдалд олон талын задлан шинжилгээ хийж, хямралт байдлаас гарах зөвлөмжүүдийг шинэ консерватив онол, юуны өмнө монетарист үзэл баримтлалуудад тодорхойлсон байна. Стагфляцийн (нэгэн зэрэг үйлдвэрлэл доройтсон, мөнгөний ханш унах) үзэгдлүүдийг эдийн засагт төрийн оролцооны «хатуу» хэлбэрүүд тогтсоноор тайлбарласан олон ном зохиол 60—80-аад онд нийтлэгджээ. Эдгээрт өгсөн үндсэн зөвлөмжүүд нь татварын тогтолцоо ба монополийн эсрэг хууль тогтоомжийг хянан үзэх, нийгмийн хүрээг хөгжүүлэн тэтгэхэд зориулсан төрийн зардлыг багасгах, «түр

ашигтай эрэлт», «ажлаар бүрэнх ангах» үзэл баримтлал дээр суурилсан удирдлагын технологиос татгалзах зэрэг үзэл санаанаас бүрдэж байв.

Наяад он бол АНУ ба Япон улсад шинэ загварт шилжих явдлыг хэрэгжүүлсэн түүхэн үе болжээ. Эдгээр орны эдийн засаг, улс төрийн бүтцэд гарсан хувьсгалт өөрчлөлтүүд нь дэлхийн зах зээл дээр бусдаас тасран урагшлан гарах бололцоог тэдэнд олгожээ.

Аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн амин чухал өөрчлөлт нь АНУ болон Япон улсад 80-аад оны эхээр хүн бүрийн хүсэмжилсэн эрэлтийг хангахад чиглэсэн зах зээлийн загварыг байгуулах зорилтыг шийдвэрлэхэд шилжин орох бололцоог өгчээ. Энэ шатны ялгарах онцлог бол төр ба үйлдвэрийн эздийн хүчин чармайлтыг өндөр технологийг бий болгох, үйлдвэрлэлийн үйл явцыг сервизчилэх, софтчилахад төвлөрүүлэх явдал юм. Шинжлэх ухаан их шингээсэн болон тусгайлсан технологи бүх салбарт өргөн нэвтэрч эхэлсэн бөгөөд тэгэхдээ энэхүү үйл явц суурь үйлдвэрлэл болон капитал их шингээсэн үйлдвэрлэлтэй харьцуулбал үйлдвэрлэлийн бус салбарт илүү түргэн хурдтай явагдаж байна. Таваарыг бүтээх дамжлагыг цөөлөх буюу технологийг софтчилах нь гуравдугаар загварын ялгарах шинж юм. Янз бүрийн прогнозоос үзвэл энэхүү загвар нь АНУ ба Япон улсад 90-ээд оны эцсээр байгуулагдах төлөвтэй бөгөөд энэ нь постиндустриал (аж үйлдвэржүүлэлтийн дараах) нийгмийн үзэл санаа хэрэгжинэ гэсэн үг юм.